



ХҮНСНИЙ НОГООНЫ СОРТУУДЫН ОНЦЛОГ, ТАРИХ ҮРИЙН ЧАНАР

Гарал үүсэл

ОХУ-ын нэрт эрдэмтэн Вавилов Н.И. хүнсний ногоог тарималжуулсан байдлаар нь 7 төв болгон хувааж гарал үүслийг тодорхойлсон байдаг. Өмнөд Азийн тропикийн төв бүс – богино өргөст хэмх, олон наст цэсийн дүрс, хулуу; Зүүн Азийн төв бүс – хятад байцаа, цагаан лууван, сармаг манжин, гич, үрт сонгино, жууцай, цэс, хэмх, амтат гуа; Өмнөд Баруун Азийн төв бүс – амтат гуа, шар лууван, сармаг манжин, улаан лууван, хэмх, бөөрөнхий сонгино, порей сонгино, сармис, вандуй, морин шош, тонх, салат; дундат далайн төв бүс – бөөрөнхий байцаа, савойн байцаа, цэцэгт байцаа, брокколи, брюсель байцаа, сармаг манжин г.м. Эдгээр бүсүүдээс гаралтай сортуудыг өнөө үед ч селекцийн эх материал болгон ашиглаж өөрийн орны сортуудыг бий болгосоор байна.

Сортод тавигдах шаардлага

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь сортод тогтвортой арвин ургац өгөх, гадаад орчны тохиромжгүй нөхцлийг тэсвэрлэх чадвартай, өвчин хортонд тэсвэртэй, механикжуулалтанд тохиромжтой, бүтээгдэхүүний чанар сайтай байх шаардлага тавьдаг. Манай оронд зонхилон бөөрөнхий байцаа, шар лууван, хүрэн манжин, сонгино зэрэг таримлуудыг тариалдаг.

Бөөрөнхий байцааны сортууд

Бөөрөнхий байцааны сортуудыг цагаан, улаан, хөх ягаан гэсэн 3 хэлбэрт ангилдаг. Ургалтын хугацаагаар сортуудыг эрт болцтой (108-115 хоног), дунд эртийн (116-130 хоног), дунд оройн (130-160 хоног), оройн (160 хоногоос дээш) гэж ангилна.

Манай оронд бөөрөнхий цагаан байцааны эрт болцтой Номер первый 147, Июньская 3200, дунд орой болцтой Белорусская 85, Белорусская 455, Ширхэнцэг 13, Хургалаг зэрэг сортуудыг нутагшуулан үрийг нь дотооддоо үржүүлж байна.



Зураг 1: Улаан өнгөнтэй байцаа (эх сурвалж: Rasbak, Wikimedia Commons)




Зураг 2: Ногоон бүрзгар байцаа (эх сурвалж: Goldlocki, Wikimedia Commons)



Зураг 3: Хургалаг сортын байцаа (эх сурвалж: Ж.Байгалмаа)

Implemented by

Шар луувангийн сортууд




Зураг 4: Шар луувангийн сорт (эх сурвалж: Ж.Байгалмаа)

Дэлхийд шар луувангийн Нантская, Flakke, Шантенэ, Imperator, Kurado хэв шинжийн сортууд түгээмэл таригддаг байна. Манайд Шантенэ хэв шинжийн Шантенэ 2461, Шантенэ Роял, нантская хэв шинжийн Нантская 4 сортуудыг нутагшуулан үрийг үржүүлэн тариалж байна.

Хүрэн манжингийн сортууд

Хүрэн манжингийн үндэс үрийн хэлбэр, махлаг эдийн бүтэц зэрэгт ихээхэн анхаарлаа хандуулдаг. Гонзгой хэлбэртэй эклипс хэв шинжийн сортууд өргөнөөр дэлгэрч байгаа хэдий ч бордо хэв шинжийнх зонхилж байдаг. Манай оронд Бордо 237, Одноростковая сортуудыг нутагшуулан үрийг нь үржүүлж дотоодын хэрэгцээг хангаж байна.



Зураг 5: Хүрэн манжингийн сортуудын хэв шинж (эх сурвалж: УГТХ-ийн архив)

Сонгинолог таримал

Сонгинолог тарималд батун, тагар, сармис болон бөөрөнхий сонгино хамрагддаг. Бөөрөнхий сонгино Дундат Азиас гаралтай улаан, цагаан, шаргал хальстай, бөөрөнхий, хавтгай бөөрөнхий зүйвэн дугуй хэлбэрийнх зонхилно. Манайд бөөрөнхий хэлбэрийн Стригуновский, хавтгай хэлбэрийн Бессоновский, Штуттгартер ризен зэрэг сортууд нутагшиж өргөнөөр тариалагдаж байна.



Зураг 6: Бөөрөнхий сонгины өнгөний ялгаа (эх сурвалж: УГТХ-ийн архив)

Тарих сорт сонгохдоо дараах зүйлийг анхаарна:

- Ургац хураалт таны сонгож тарьсан сортоос шалтгаална – эрт, дунд, орой болц,
- Бүтээгдэхүүний чанар таны тарих болон хураалт хийх хугацаанаас шалтгаална,
- 1 га талбайгаас авах ургамлын тоо – таны хүсэж буй ургацын үзүүлэлт,
- Таны өөрийн тариалангийн бүс нутагт сонгосон сорт, тарьсан хугацаа хэр зэрэг тохиромжтой эсэх,
- Талбайн нөхцөлд бүрэн болц гүйцэж буй хугацааг тооцоолох,

Сортын үрийн чанар

Хүнсний ногооны сортын үрийн гол чанар нь түүний сортын цэвэршилт юм. Сортын цэвэршилтийг I, II, III анги гэж ангилахаас гадна үрийн стандартад нийцсэн байна. I, II-р ангид өөр бусад сорт болон эрлийзийн хольцгүй байна.



Зураг 7: Сонгино, хүрэн манжин, байцаа, хэмх, амтат чинжүүний үр (эх сурвалж: Ж.Байгалмаа)

Сортын тарих үрийн чанар



Сортын тарих үрийн чанарт нь соёололт, амьдрах чадвар, цэвэршилт, 1000 ширхэг үрийн жин, чийгшилт, ургах эрчим, үндсэн таримлын үрийн агуулалт, өвчин хортонд нэрвэгдсэн байдал зэргээр илэрхийлэгдэнэ. Эдгээр үзүүлэлтүүдийг лабораторын нөхцөлд тодорхойлж үнэлгээ өгнө.

Зураг 8: Соёолуулсан үр (эх сурвалж: Г.Ганболд)

Хүнсний ногооны үрийн чанарын үзүүлэлт:

Таримал	Хадгалах хугацаа (жил)	Соёолох хамгийн бага t0	+200хэмд соёолох хоног	1г дахь үрийн тоо, ш
Тарвас	6-8	13-15	6-15	6-25
Амтат гуа	6-8	10-12	4-8	30-35
Цэс	3-5	13-14	8-14	200-250
Чинжүү	3	14-15	14	120-200
Лооль	3-5	22-25	8	300-330
Цагаан лууван	3-5	2-4	8-15	100-140
Бөөрөнхий байцай	4-5	2-3	5-10	250-300
Брокколи	4-5	2-3	5-10	200-350
Хятад байцай	4-5	2-3	5-10	200-330
Цэцэгт байцай	4-5	2-3	5-10	250-330
Бөөрөнхий сонгино	3-4	3-5	12	200-250
Порей сонгино	3-4	3-5	12	350-500
Шар лууван	3-5	4-5	10	700-1250
Хүрэн манжин	4	20-22	8	50-70
Хэмх	6-8	13-15	4-8	40-50
Бууцай	2-3	15-20	10	100-175
Салат	3-4	15-17	4	600-1100

ЗӨВЛӨМЖ

Бүс нутагт тохирсон хүнсний ногооны таримлуудын сортыг сонгохдоо дараах зүйлийг анхаарна:

- Сортын ургацын чадавхи,
- Сонгох сорт нь таны бүс нутагт тохирох эсэх,
- Тухайн бүс нутгийн хэрэглэгчдийн сонирхолд нийцэх эсэх,
- Сортын зориулалт,
- Хадгалалт даах чадвар,

Тухайн бүс нутагт дасан зохицсон сортыг тариалахад нэмэгдэл зардал гаргахгүйгээр хөрс цаг уурын нөөцийг бүрэн ашиглаж таримлын ургацыг 25-30%, заримдаа 50% хүртэл нэмэгдүүлэх боломжтой байдаг тул сортыг зөв сонгох хэрэгтэй.

Ашигласан хэвлэл:

Марков В.М., “Овощеводство”, Москва 1974

Лудилов В.А., “Семеноведение овощных и бахчевых культур”, Москва 2004

Сборник научных трудов “Селекция и семеноводство овощных культур”, Москва 2014

Старцев В.И., “Овощеводство – Арготехника капусты”, Москва 2013

Пивоваров В.Ф. и др. “Луковые культуры”, Москва 2001

Чулуунбаатар Ж., “Ногооны аж ахуй”, УБ 2011

Эмхэтгэн боловсруулсан:	Герман-Монголын Хамтын Ажиллагааны „Тогтвортой Хөдөө Аж Ахуй“ Төсөл
Хаяг:	Засгийн газрын IXа байр, Энхтайвны өргөн чөлөө 16а, Улаанбаатар 13381, Монгол улс
Мэйл:	project.mn@iakleipzig.de
Вэб хуудас:	www.dmknl.de
Текст	УГТХ-ийн хүнсний ногоо судлалын секторын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Ж.Байгалмаа
Тайлбар	Энэхүү мэдээллийн богцонд багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.